

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТЭТГЭМЖ АВАХ ӨРГӨДӨЛ ГАРГАХ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

14 дүгээр зүйл.Тэтгэмж авах өргөдөл гаргах хугацаа

Хэвлэх

14.1.Даатгуулагч, иргэн тэтгэмж авах өргөдлөө нийгмийн даатгалын байгууллагад дараах хугацаанд цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

14.1.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

14.1.2.нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

14.1.3.ажилгүйдлийн тэтгэмж авах даатгуулагч ажлаас чөлөөлсөн тухай ажил олгогчийн шийдвэр гарсан өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор.

15 дугаар зүйл.Өргөдлийг шийдвэрлэх хугацаа

Хэвлэх

15.1.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн тэтгэмж авахыг хүссэн өргөдлийг энэ хуулийн 15.2-т заасан журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт хүлээж авснаас хойш хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж олгох асуудлыг 14 хоногийн дотор, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

15.2.Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

15.3.Энэ хуулийн 15.1-д заасан өргөдлийн маягтын загвар, тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг авах эрх бүхий иргэн, албан тушаалтныг тодорхойлох журам, тэтгэмж бодох аргачлал, зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

22 дугаар зүйл. Тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

Хэвлэх

22.1. Даатгуулагч тэтгэвэр тогтоолгох шаардлагатай баримт бичиг, өргөдлийг доор дурдсан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

22.1.1. өндөр насны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгон авахыг хүссэн хугацаанд;

22.1.2. хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосноос хойш 14 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол гурван сарын дотор;

22.1.3. тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэжээгч нь нас барснаас хойш 30 хоногийн, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор.

22.2. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагч, эсхүл даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэвэр тогтоох асуудлыг түүний тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

22.3. Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

22.4. Тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар, тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам, тэтгэвэр бодох зааврыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

11 дүгээр зүйл. Тэтгэвэр, тэтгэмж авах өргөдөл гаргах, түүнийг шийдвэрлэх хугацаа

Хэвлэх

11.1. Даатгуулагч, иргэн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдлийг бүрдүүлсэн баримт бичгийн хамт дараах хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

11.1.1. хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоолгосноос хойш 14 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 3 сарын дотор;

11.1.2. тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ нас барснаас хойш 30 хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

11.1.3. хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах даатгуулагч эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан үйлдвэрлэлийн ослын акт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолт авснаас хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор;

11.1.4. нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах иргэн даатгуулагчийг нас барснаас хойш 6 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол 6 сарын дотор.

11.2. Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчид хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох асуудлыг түүний тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 14 хоногийн дотор, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 24 цагийн дотор шийдвэрлэнэ.

11.3. Даатгуулагч энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална.